*Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!*

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

*Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.*

18 дахь жилдээ №19 (1420) | 1965 оны 3 дугаар сарын 11 | ПҮРЭВ

## Бодын хөөвөр, ямааны ноолуур бэлтгэх цаг боллоо

Одоо манай эх орон даяар бодын хөөвөр, тэмээний өвдөг, зогдорын ноос авах, ямаа самнах ажил ид өрнөлөө.

Тус аймаг өнгөрсөн жил дунджаар нэг бодоос 314 гр хөөвөр, 546 гр хялгас, ямаа бүрээс 250 гр ноолуур ашиглаж төлөвлөгөөнөөс бодын хялгас 3,5 тонн, хөөвөр 5,2 тонн, ноолуур 1,1 тонныг тус тус илүү бэлтгэж бодын хялгас, хөөвөр, ямааны ноолуурын төлөвлөгөөг бүх сум жигд биелүүлж үнэхээр сайхан амжилт гаргасан юм.

Энэ ажилд Өндөрширээт, Өнжүүл, Батсүмбэр, Бзян сумдын хамт олон гарамгай сайн ажилласан юм.

1964 оны аймгийн ноолуурын аварга Эрдэнэсант сумын Содномцэрэн нэг ямаанаас 371 гр ноолуур ашиглаж бүх авсан ноолуур нь нэгдүгээр зэрэгт оржээ.

Эдгээр амжилт бол манай аймгийн нам, улс, худалдаа бэлтгэл, ХАА, олон нийтийн байгууллага, нийт хөдөлмөрчдийн хамтын чармайлт, хөдөлмөрийн зөв зохион байгуулалт бүх хүмүүсийн шургуу бүтээлч ажиллагааны үр дүн билээ. Манай аймгийн нэг малаас авах ноосны хэмжээ энэ онд улсын дундаж нормоос илүү байгаа нь улам шургуу хөдөлмөрлөхийг биднээс шаардаж байна. Манай аймаг нэг адуунаас дэл 410 гр, сүүл 110 гр, хөөвөр 310 гр, үхрээс хөөвөр 310 гр, сүүл 0,5 гр, сарлагнаас савга 560 гр, сүүл 0,50 гр, хөөвөр 550 гр. нэг ямаанаас 260 гр ноолуур тус тус ашиглаж байж улсын төлөвлөгөөг биелүүлэх болно.

Иймд цаг хугацаа алдалгүй ажиллаж нэг малаас ашиглах ноосны хэмжээг нормоос илүү давуулан авч байж улсаас өгсөн төлөвлөгөөг давуулан биелүүлж чадах учрыг нийт малчид хөдөлмөрчид ойлгох нь чухал байна.

Хэрэв цаг хугацаа алдвал бодын хөөвөр гээгдэж, ямааны ноолуурын чанар муудан улсын төлөвлөгөө биелэгдэхгүйд хүрнэ.

Иймд одоогийн гол зорилт болсон төл бойжуулах ажилтай хамт адуу, үхэр хөөвөрлөх, дэл хялгасы нь авах, ямаа самнах, тэмээний эр ноос авах ажлаа зэрэгцүүлэн нарийн зохион байгуулалттай хийх нь чухал байна.

Энэ ажилд нам, ХЗЭ, үйлдвэрчний эвлэл болон олон нийтийн бусад байгууллагуудыг татан оролцуулж ажлыг нь богино хугацаанд дүгнэн тэргүүний хүмүүсийн туршлагыг сурталчлан дэлгэрүүлэх ажлыг эрчимтэй зохиох нь чухал.

Бодын хөөвөр, ямааны ноолуур, тэмээний ноос авахад нэг анхаарах гол асуудал бол чанар юм.

Чанар сайтай ноос бэлтгэхийн тулд анх ноос авч байгаа газар дээр нь адуу, үхрийн хөөврийг хооронд нь холилгүйгээр тус тусд нь мөн адууны дэл, богино сүүлийг холилгүй тус тусд нь бас цагаан өнгийн хялгасыг бусад өнгийн хялгаснаас тусгай савлах мэтийн өнгө төрлийн ялгалтыг сайн хийх хэрэгтэй.

Ингэвэл нийгмийн ба амины орлогыг нэмэгдүүлж, улсаас ажиллагааны илүү зардал гаргахгүй юм.

Мөн тэмээний ноосны өвсийг түүж сэгсрэх ажлыг сайн хийх нь чухал.

Ямааны ноолуурын чанарыг муутгахгүйн тулд 1,2,3 дугаар самналт тус бүрээр нь авсан ноолуурыг тус тусд нь савлахын зэрэгцээгээр ямааны дал, бөөр, хүзүүний хэсгээс самнаж авсан хялгас багатай сайн чанарын ноолуурыг гуя, хонго, нуруу ны дагуух дээд хэсэг, харьд богтосны хэсгийн хялгас ихтэй ноолууртай холилгүй савлаж тушаах нь чухал юм.

Нөгөө талаар 1 дүгээр ба 2 дугаар самналт хийсэн ямааг тэмдэглэж байвал нэг ямааг олон дахин самнаж цаг үрэх, нөгөө ямааг самналгүй орхиж ноолуурыг нь гээгдүүлэх явдал гаргахгүй гэдгийг анхаарч ажиллавал зохино.

Ямааны ноолуурыг амархан хөөрүүлэхийн тулд «ялангуяа шүдлэн ямааны» урьдаар үсний нь ээдрээг гаргаж самнах, ноолуурын гарцы нь нэмэгдүүлэхийн тулд маш ойрхон зайтай олон шүдтэй самаар самнах аргуудыг хэрэглэх нь чухал байна.

Худалдаа бэлтгэлийн анги, бэлтгэлийн эрхлэгч агентуудын чухал нэг үүрэг бол төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж шаардахын зэрэгцээгээр гарч байгаа зүйлийг аль болохоор түргэн цуглуулан авч, чанар байдлыг нарийн шалгаж илэрсэн дутагдлыг нийтэд ойлгуулан цаг тухайд нь засуулах явдал мөн.

### ХАВАР

**Энэ жил манай аймаг 382580 хурга, ишиг бойжуулж авна.**

...ала... үйлд- ...н түм... мөн.

...уу

Хот, орноо улам боловсон тохилог болгоё

## Зуун мод хорооны АДХ-ын 6 дахь удаагийн 5 дугаар чуулган

Энэ чуулган хот орноо тохижуулах талаар зохион явуулсан 1964 оны ажлын дүн ба 1965 онд тавих зорилтын тухай асуудал авч хэлэлцэв.

Зуунмод хороо захиргаа, аймгийн төвийн олон нийт, үйлдвэр аж ахуй, соёлын байгууллагуудын туслалцаа дэмжлэгтэйгээр аймгийн төвөө тохижуулах, соёлжуулах талаар өнгөрсөн хугацаанд багагүй зүйлийг хийж бүтээжээ.

Ялангуяа 1962—63 онуудад аймаг байгуулагдсаны 40 жилийн ойг угтаж улсын төсөв ба аж ахуйн аргаар ажилчин албан хаагчид хөдөлмөрчдийн хүчийг зохион байгуулалттай оролцуулан биеийн тамирын заал, зочид буудал, гуанз, орон сууцны хэд хэдэн барилга зэргийг барьж ашиглалтанд оруулсны гадна цэцгийн мандал, хиймэл нуур байгуулан төв талбайд хүндэт самбар бий болгон, хайс хашлагыг шинэчлэн засварлах, гудамж талбайг тэгшлэх, албан байгууллага ажилчдын байрлалыг тогтоох, хүүхдийн тоглоомын талбай ба зуслан байгуулах зэрэг нилээд ажлууд зохиож ирсний гадна 1964 онд аймгийн төвийн нийт оршин суугчдын байрлалын талаар нь 8 хорин болгон зохион байгуулж гудамж орон сууцны талбайг тэгшлэх, хашаа хаалгыг үзэмжтэй болгохын тулд 137 айлын хашааг шинэчлэн засуулж, 21 албан байгууллагын ажилчин албан хаагчдыг нэгдсэн байрны хашаатай болгож, задгай замбраагүй байрласан айл өрхүүдийг зохион байгуулалттай болгож гудамжуудыг нэртэй болгон 20 гудамж, 213 хашаанд номер олгожээ. Мөн аймгийн төвийн гудамж талбайг тэгшитгэн 2000 гаруй куб метр газар шорооны ажил хийж, нийтийн хог хаях ажлыг цөмхөтгөн журам тогтоосон байна.

Ариун цэвэрч болгох, соёлжуулах асуудалд нийт хөдөлмөрчдийг нилээд идэвхтэй оролцуулж байна. Аймгийн төвийг бүхэлд нь хамарсан нийтийн цэвэрлэгээ 7 удаа хийлгэж муу усны нүх, жорлон зэрэг шаардлагатай зүйлүүдийг бий болгож айл өрх, гудамж хорины ариун цэврийн комисс нарт үе үе зөвлөлгөөн семинар өгч байсан нь үр дүнгээ өгч байна.

Төв саадыг тохижуулахын тулд 1000 гаруй мод суулгаж, 200 метр газар бетон хашлага хийж, баримал нэгийг тавьсан ба фантоныг сэлбэн засаж дөрвөн талд нь хаалга хийлгэж 530 метр газарт цемент суурь цутгаж хурлын индэр, 40 жил хаалганы дэргэдэх баримлуудыг засуулж, Зуун модны голоос салбар шуудуугаар урсаж аймгийн төвийн барилгад муугаар нөлөөлж байсан усыг хөдөлмөрчдийн хүчээр боож жинхэнэ хэвийн урсгалд нь оруулсан байна.

Гэвч хот суурингаа тохижуулах, ялангуяа байр орон сууц, албан конторын ойр орчныг боловсон тохилог болгож цэвэр үзэмжтэй байлгах, гудамж талбайг нэг журамтай болгож, гэрэлтүүлэх асуудал бүрэн хийгдэж чадаагүй, мод цэцэрлэгийг өргөтгөн арчилж хамгаалах явдалд муу анхаарснаас гадна хот орны тохижилт соёлжилт ялангуяа хотын ариун цэвэр, үйлчилгээ айл өрхүүдийн соёлжилтын талаар тавих шаардлага хороо захиргааны удирдах хүмүүсүүд дээр хангалтгүй байгааг депутатууд шүүмжлэн хэлэлцэв.

Тус чуулган аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 6 дугаар чуулганаар батлагдсан 1965—66 онд явагдах соёлжилтын 2 жилийн зохистой ажлын ерөнхий төлөвлөгөөнөөс үндэслэн тус хороо захиргаанаас 1965—66 онд хотоо тохижуулах талаар хийх ажлын төлөвлөгөө батлав. Энэ төлөвлөгөөнд тус аймгийн нийт албан байгууллагын орчин тойрны газруудыг тэгшилж засах ба албан конторын гадуур мод тарих, зүлэг суулгах ажлыг нийт албан байгууллага бүрээр зохион байгуулалттай ажиллуулах; Нийт албан газруудын бие засах газруудыг эмх цэгцтэй болгож нэг маягийн өнгө үзэмжтэй бие засах жорлонтой болгох ажлыг зохион байгуулалттай өөрсдийн хүчээр хийлгэх. Аймгийн төвийн саадны доторх талбайд мод тарих, дөрвөн талын замыг цардмал болгож хөдөлмөрчдийн зугаалга, хүүхдийг саатуулах, эрүүлжүүлэх явдалд тохиромжтой болгохын хамт өдрийн гэрэлтүүлэгтэй болгохын тулд тоног төхөөрөмжөөр бүрэн хангах; Хотын доторх албан үйлдвэр, үйлчилгээний газруудын гадна талаар нэг загварын үзэмжтэй хайсан хашаатай болгон гэрэл чимэглэл тавиулах; Нийт албан газар, нэгдсэн байрны сууцны барилгын дэргэд хувийн барилга, айл өрх байрлах явдлыг бүрмөсөн зогсоож, мод тарих, зүлэг суулгах, хүүхдийн тоглоомын талбай байгуулах;

Ажилчин албан хаагчдын өвлийн нэгдсэн байрыг сонгон цэвэр үзэмж бүхий хашаатай болгон байрлуулах ба хувийн хашаа байшинтай айлуудыг нэгэн адил зохион байгуулалттай байрлуулж хашаа хаалганы чанарыг эрс сайжруулан нэг үзэмж загвартай болгож нэг өнгийн будгаар будуулах, дутууг гүйцээж хаягтай болгох;

Цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэдэх хиймэл нуурыг тохижуулж засах, мод тариалах ажлыг Эвлэлийн хороо, Ургац нийгэмлэгтэй хамтран залуучуудын хүчээр хийлгэх.

Аймгийн төвийн хөдөлмөрчдийн зугаалга, амралтын талбайг сонгон авч байгуулах.

Аймгийн төвийн зуны лагерийн байранд хөнгөн маягийн 8 айлын орон сууцны байшинг үйлчлэх товчоогоор бариулах.

Лагерийн байрыг сонгон авч радио утсан харилцаа, чийдэн тавиулах ажлыг зохион байгуулалттай тавиулах ба биеийн тамирын талбай, идэш ууш, цагаан идээний мухлагийг байгуулах зэрэг аймгийн төвийг тохижуулах олон зүйл төлөвлөгдсөнийг депутатууд санал нэгтэй батлав.

*Н.Мөнхөө*

